

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ
УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖААС
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

2011 оны ... сар ... өдөр

Улаанбаатар хот

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд заасны дагуу “Иргэний цахим үнэмлэх олгох бэлтгэл ажлыг хангах”, “Иргэний цахим үнэмлэхийг үе шаттайгаар олгох” арга хэмжээний хүрээнд иргэдийг Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.1-д заасан тэмдэгтийн хураамжаас нэг удаа чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2011 оны 12 дугаар сарын 1-нээс 2012 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ